



СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 4/309

Сүхбаатар сум

Дэмжлэг үзүүлэх тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.5."а", Биеийн тамир, спортын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, 8.1.2, 10 дугаар зүйлийн 10.1.2, 10.1.7, аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.3.10, Монгол Улсын Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 239 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3, 4 дүгээр зүйлийн 4.2 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Улаанбаатар хотод 2020 оны 10 дугаар сарын 28-наас 11 дүгээр сарын 01-ний өдрүүдэд зохион байгуулагдах өсвөрийн шатарчдын Улсын аварга шалгаруулах тэмцээнд аймгаа төлөөлөн оролцох өсвөрийн баг тамирчдад шаардлагатай зардлыг хавсралтаар баталсугай.

2.Тэмцээнд шаардагдах 3012800 /гурван сая арван хоёр мянга найман зуун мянган/ төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /О.Мөнхбаяр/-т зөвшөөрсүгэй.


3.Өсвөрийн шатарчдын "Улсын аварга шалгаруулах тэмцээн"-ний зардлын тайланг аймгийн Засаг даргын Тамгын газарт 2020 оны 11 дүгээр сарын 09-ны дотор ирүүлэхийг Биеийн тамир, спортын газрын дарга /У.Батмөнх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ш.ОРГИЛ

Сэлэнгэ аймгийн Засаг даргын
2020 оны 10-р сарын 27 -ны өдрийн
А/ЗСГ тоот захирамжийн хавсралт



Өсвөрийн шатарчдын “Улсын аварга шалгаруулах тэмцээн”-ний
төсөв

2020.10.21

№	Зардлын нэр	Агуулга	Нэгжийн үнэ	Тоо хэмжээ	Дүн
1	Тээвэр		7600	28	212800
2	Байр	4 хоног	50000	28	1400000
3	Хоол	5 хоног	10000	28	1400000
Нийт дүн					3012800

Тайлбар: Байрны зардал нэг өрөөнд 4 хүүхэд нийт 7 өрөө

Төсөв зохиосон:

Т.Мягмарцэнд
/АЗТГ-ын НБХ-ийн мэргэжилтэн/

Төсөв хянасан:

Ц.Уранцэцэг
/АЗДТГ-ын нягтлан бодогч/